

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/03-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2024 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:bolort@audit.gov.mn">bolort@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-21
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	22-24
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. Аудитын илрүүлэлт	25-28
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	29-30

## **Товчилсон үгийн жагсаалт**

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БТСГ	Биеийн тамир спортын газар
БХНС	Байгаль хамгаалах нөхөн сэргээх
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Р.БАТЖАРГАЛ ТАНАА

2024.03.25 № СЭА-2024/03-НА-СТА-773

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сумын ИТХ-ын “Баянгол сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 89 дүгээр тогтоолоор тайлант онд 1,172,925.9 мянган төгрөгийн татварын орлого, 216,804.8 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт 1,389,730.7 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 2,083,619.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 49.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 1,138,219.4 мянган төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг

боловсруулж, баталсны дагуу шууд худалдан авах 3, харьцуулалтын аргаар гүйцэтгэх 3, нээлттэй тендер шалгаруулах 4, нийт 10 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Баянгол сумын Засаг дарга нь тайлант онд 17 зорилт, 231 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.6 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## **2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

### **2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр/

<b>Код:</b>	<b>Тайлангийн үзүүлэлт</b>	<b>2022 оны 12-р сарын 31</b>	<b>2023 оны 12-р сарын 31</b>
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,520,356.80</b>	<b>2,037,935.40</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>704,095.30</b>	<b>943,021.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>218,961.00</b>	<b>257,107.20</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>597,300.50</b>	<b>837,807.20</b>
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,897,148.60</b>	<b>4,784,836.40</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,897,148.60</b>	<b>4,784,836.40</b>
39200	Биет хөрөнгө	3,792,046.30	4,680,596.60
39300	Биет бус хөрөнгө	105,102.30	104,239.80
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,417,505.40</b>	<b>6,822,771.80</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>60,531.20</b>	<b>67,036.70</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>60,531.20</b>	<b>67,036.70</b>
41300	Өглөг	60,531.20	67,036.70
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,356,974.20</b>	<b>6,755,735.10</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,356,974.20</b>	<b>6,755,735.10</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,264,860.60	1,264,860.60
51200	Хуримтлагдсан үр дүн	2,615,475.50	4,014,236.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,476,638.00	1,476,638.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,417,505.40</b>	<b>6,822,771.80</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,528,972.20</b>	<b>4,284,129.50</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>932,259.80</b>	<b>1,497,882.50</b>
110	Орлогын албан татвар	577,219.60	954,952.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	577,219.60	1,049,201.20
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(94,248.70)
113	Хөрөнгийн албан татвар	217,490.20	326,258.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	137,550.00	216,671.90
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,006,559.80</b>	<b>1,671,014.80</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,006,559.80	1,671,014.80
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,590,152.60</b>	<b>1,115,232.20</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,151,643.50</b>	<b>2,016,840.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,151,643.50</b>	<b>2,016,840.90</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,651,650.50	1,976,644.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	497,562.20	624,697.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,754.70	78,096.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	415,736.30	82,235.20
2104	Хангамж, бараа материалын зардал	48,748.50	67,950.60
2105	Нормативт зардал	2,060.00	2,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,553.90	60,605.90
2107	Томилолт, зочны зардал	7,642.40	5,375.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,517.10	567,077.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	535,075.50	488,505.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,499,993.00	40,196.60
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,377,328.80</b>	<b>2,267,288.70</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>7,846,120.80</b>	<b>868,527.80</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(6,468,792.10)</b>	<b>1,398,760.90</b>

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,005,491.10	-	12,005,491.10
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(179,724.80)	-	(179,724.80)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,825,766.30	-	11,825,766.30
9	Тайлант үеийн үр дүн	(6,468,792.10)	-	(6,468,792.10)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,356,974.20	-	5,356,974.20
<b>11</b>	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>5,356,974.20</b>	-	<b>5,356,974.20</b>
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,356,974.20</b>	-	<b>5,356,974.20</b>
19	Тайлант үеийн үр дүн	1,398,760.90	-	1,398,760.90
<b>20</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>6,755,735.10</b>	-	<b>6,755,735.10</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,931,126.30</b>	<b>3,206,758.10</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>932,259.80</b>	<b>1,497,604.80</b>
110	Орлогын албан татвар	577,219.60	954,952.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	577,219.60	1,049,201.20
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(94,248.70)
113	Хөрөнгийн албан татвар	217,490.20	326,258.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	137,550.00	216,394.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	23,014.20	15,715.20
1181	Газрын төлбөр	92,133.00	171,240.90
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	22,402.80	29,438.10
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>350,820.60</b>	<b>625,375.80</b>
120	Нийтлэг татварын бус орлого	350,820.60	625,375.80
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,648,045.80</b>	<b>1,083,777.50</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,787,327.80</b>	<b>1,579,840.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,787,327.80</b>	<b>1,579,840.20</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,219,298.70	1,539,643.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	497,562.20	624,697.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,754.70	78,096.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	415,736.30	82,235.20
2104	Хангамж, бараа материалын зардал	48,948.50	67,950.60
2105	Нормативт зардал	2,060.00	2,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,443.90	45,383.00
2107	Томилолт, зочны зардал	7,642.40	5,375.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,251.10	567,077.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,899.70	66,727.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,568,029.10	40,196.60
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,143,798.40</b>	<b>1,626,917.90</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>1,324,841.00</b>	<b>1,212,992.30</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,324,841.00</b>	<b>1,212,992.30</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	1,324,841.00	1,212,992.30
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(1,324,841.00)</b>	<b>(1,212,992.30)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(90,000.00)</b>	<b>(175,000.00)</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>90,000.00</b>	<b>175,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(271,042.50)</b>	<b>238,925.70</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	975,137.80	704,095.30
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	704,095.30	943,021.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,984,015.00</b>	<b>2,812,146.30</b>	<b>171,868.70</b>	<b>94.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,670,795.60</b>	<b>1,589,693.84</b>	<b>81,101.76</b>	<b>95.15</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,626,235.30</b>	<b>1,549,497.23</b>	<b>76,738.07</b>	<b>95.28</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	641,488.60	619,411.22	22,077.38	96.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,186.10	77,914.66	2,271.44	97.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	549,793.00	541,692.39	8,100.61	98.53
2104	Хангамж, бараа материалын зардал	69,692.00	65,231.00	4,461.00	93.60
2105	Нормативт зардал	2,510.80	2,100.00	410.80	83.64
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	123,861.20	117,351.30	6,509.90	94.74
2107	Томилолт, зочны зардал	8,974.20	5,375.20	3,599.00	59.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	77,172.30	64,495.76	12,676.54	83.57
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,557.10	55,925.70	16,631.40	77.08
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,560.30</b>	<b>40,196.61</b>	<b>4,363.69</b>	<b>90.21</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,560.30	40,196.61	4,363.69	90.21
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,138,219.40</b>	<b>1,047,452.46</b>	<b>90,766.94</b>	<b>92.03</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>175,000.00</b>	<b>175,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,984,015.00</b>	<b>2,703,969.22</b>	<b>280,045.78</b>	<b>90.62</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,462,615.70</b>	<b>2,585,593.03</b>	<b>(122,977.33)</b>	<b>104.99</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>521,399.30</b>	<b>118,376.19</b>	<b>403,023.11</b>	<b>22.70</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	306,281.87	(306,281.87)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	198,104.80	(198,104.80)	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>80.00</b>	<b>80.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2.00</b>	<b>2.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>39.00</b>	<b>39.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>39.00</b>	<b>39.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>180,161.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>51,165.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>26,689.79</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		5,286.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		182.05
2104	Хангамж, бараа материалын зардал		2,719.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		10,801.66
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>24,475.22</b>
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		24,475.22
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>128,996.36</b>
2200	Дотоод эх үүсвэрээр		128,996.36
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>180,161.36</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		180,161.36

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагч *Ицаашид Баянгол сумын ТТЗ гэх* нь “*Өрхийн үйлдвэрлэлийг дэмжин иргэн, өрх бүрийг ажил орлоготой байлгах боломжийг хамтын хичээл зүтгэлээр бүрдүүлж, эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай иргэн төвтэй бүсийн загвар сум болох*” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

2023 онд Баянгол сумын ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянгол сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад, сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дээрх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,405,266.4 мянган төгрөгөөр буюу 33.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	704,095.3	943,021.0	238,925.7
Авлага	218,961.0	257,107.1	38,146.2
Бараа материал	597,300.5	837,807.2	240,506.7
Үндсэн хөрөнгө	3,897,148.6	4,784,836.4	887,687.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,417,505.4</b>	<b>6,822,771.8</b>	<b>1,405,266.4</b>
Өр төлбөр	60,531.2	67,036.7	6,505.5
Засгийн газрын хувь оролцоо	5,356,974.2	6,755,735.1	1,398,760.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,417,505.4</b>	<b>6,822,771.8</b>	<b>1,405,266.4</b>

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудыг тус бүрээр нь тайлбарлан доор харуулав.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 943,021.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 238,925.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	704,095.3	943,021.0	238,925.7
Төгрөг	704,095.3	943,021.0	238,925.7
Төрийн сангийн харилцах	704,095.3	943,021.0	238,925.7
<b>Дүн</b>	<b>704,095.3</b>	<b>943,021.0</b>	<b>238,925.7</b>

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 677,879.5 мянган төгрөг ОНХО-ын дансанд, 90,173.3 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 107,931.5 мянган

төгрөг ХХС-ийн дансанд, 67,036.7 мянган төгрөг БХНС барьцаа дансанд / Хөрөнгө оруулалтын барьцаа дансгүйгээс тайлант онд сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн “Гэр хорооллын явган хүний замыг хатуу хучилттай болгох” ажлын 22,601.7 мянган төгрөгийг барьцааг тус дансанд байршуулсан./ тус тус байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 257,107.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 38,146.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татаас, санхүүжилтийн авлага	31,454.7	-	(31,454.7)
Зээлийн хүүгийн авлага	3,627.5	1,685.9	(1,941.6)
Хувь хүмүүст олгосон зээл	123,878.8	155,417.8	31,539.0
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	60,000.0	100,003.5	40,003.5
<b>Дүн</b>	<b>218,961.0</b>	<b>257,107.1</b>	<b>38,146.2</b>

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- ХХС-ийн зээлийн 255,421.3 мянган төгрөг, зээлийн хүүгийн 1,685.9 мянган төгрөгийн авлага байна.

Авлагын дансны үлдэгдэлд хугацаа хэтэрсэн 24,312.8 мянган төгрөгийн дараах авлагууд байна. Үүнд:

- ХХС-ийн зээлийн хүүгийн 1,365.3 мянган төгрөгийн авлага,
- ХХС-ийн зээлийн 22,947.5 мянган төгрөгийн авлага байна.

Тайлант онд хугацаа хэтэрсэн /2013-2020 оны хооронд зээл авсан/ 54,359.3 мянган төгрөгийн зээлийн авлагаас 3 зээлдэгчийн 30,046.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 837,807.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 240,506.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бэлэн бүтээгдэхүүн	5,980.6	-	(5,980.6)
Хангамжийн материал	496,319.9	742,807.2	246,487.4

Бичиг хэргийн материал	2,293.5	2,608.6	315.1
Аж ахуйн материал	2,359.5	2,365.5	6.0
Бусад хангамжийн материал	491,666.9	737,833.1	246,166.3
<b>Мал амьтад</b>	<b>95,000.0</b>	<b>95,000.0</b>	-
<b>Дүн</b>	<b>597,300.5</b>	<b>837,807.2</b>	<b>240,506.7</b>

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь тайлант онд сумын ОНХС-ийн эх үүсвэрээр дутуу хэрэгжсэн 179,605.4 мянган төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг бүртгэсэн, тайлант онд худалдан авсан бараа материалаас зарцуулаагүй үлдэгдэлтэй тайлагнаснаас шалтгаалсан байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 4,784,836.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 887,687.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	2,523,143.6	3,425,511.7	902,368.0
Авто-тээврийн хэрэгсэл	45,693.0	27,432.4	(18,260.6)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	152,364.6	229,952.5	77,587.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	38,448.4	28,527.8	(9,920.5)
Зам, гүүрийн байгууламж	550,205.4	465,235.6	(84,969.8)
Бусад үндсэн хөрөнгө	362,196.7	283,945.7	(78,251.0)
Дуусаагүй барилга, байгууламж	119,994.5	219,990.9	99,996.4
Программ хангамж	1,546.9	684.4	(862.5)
Бусад биет бус хөрөнгө	103,555.4	103,555.4	-
<b>Дүн</b>	<b>3,897,148.6</b>	<b>4,784,836.4</b>	<b>887,687.8</b>

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 79,996.4 мянган төгрөгийн уурын зуухны шинэчлэлийн ажил,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 49,000.0 мянган төгрөгийн малын тэжээл нөөцлөх төхөөрөмж,
- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 819,375.3 мянган төгрөгийн Гэр хорооллын явган хүний замыг хатуу хучилттай болгох, Цахим худаг, худаг засвар, Худаг гаргах, Мал ариутгалын дүк машин худалдан авах, Ковш худалдан авах, Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил 7 төсөл, арга хэмжээг тус тус комиссын актаар хүлээн авч, бүртгэл тайланд тусгасан нь голлон нөлөөлсөн байна.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 67,036.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,505.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	31,454.7	-	(31,454.7)
Байгууллагад төлөх өглөг	27,650.6	67,036.7	39,386.2
Хувь хүмүүст төлөх өглөг	1,426.0	-	(1,426.0)
<b>Дүн</b>	<b>60,531.2</b>	<b>67,036.7</b>	<b>6,505.5</b>

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх онд нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлагыг бүрэн хүлээн авсан, БХНС барьцаа дансанд байршуулсан 67,036.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг байгууллагад төлөх өглөгөөр тайлагнаснаас голлон шалтгаалсан байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 6,755,735.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,398,760.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Засгийн газрын оруулсан капитал</b>	<b>1,264,860.6</b>	<b>1,264,860.6</b>	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,615,475.5</b>	<b>4,014,236.4</b>	<b>1,398,760.9</b>
Өмнөх үеийн үр дүн	9,084,267.6	2,615,475.5	(6,468,792.1)
Тайлант үеийн үр дүн	(6,468,792.1)	1,398,760.9	7,867,553.0
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>1,476,638.0</b>	<b>1,476,638.0</b>	-
<b>Дүн</b>	<b>5,356,974.2</b>	<b>6,755,735.1</b>	<b>1,398,760.9</b>

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын “Баянгол сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 72 дугаар тогтоолоор тайлант онд 1,172,925.9 мянган төгрөгийн татварын орлого, 216,804.8 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт **1,389,730.7** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **2,083,619.7** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 49.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын орлого</b>	<b>1,172,925.9</b>	<b>1,497,604.7</b>	<b>324,678.8</b>	<b>127.7</b>
Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого	693,504.60	969,965.00	276,460.4	139.9
Үйл ажиллагааны орлого	43,300.00	44,162.90	862.9	102.0
Хөрөнгийн орлого	10,000.00	25,966.30	15,966.3	2.5 дах
Хөрөнгө борлуулсны орлого	15,000.00	9,107.00	-5,893.0	60.7
ХХОАТ-ын буцаалт	(94,248.70)	-94,248.7	0.0	100.0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	100,000.00	93,442.7	-6,557.3	93.4
Бууны албан татвар	1,300.00	1,230.0	-70.0	94.6
Малд ногдуулах албан татвар	298,500.00	231,585.4	-66,914.6	77.6
Улсын тэмдэгтийн хураамж	6,000.00	2,154.7	-3,845.3	35.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.00	2,314.5	1,814.5	4.6 дах
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12,000.00	11,246.0	-754.0	93.7
Газрын төлбөр	66,621.00	127,191.3	60,570.3	190.9
Дуудлага худалдаа	5,432.00	44,049.5	38,617.5	8.1 дах
Ойн нөөц ашигласны төлбөр	2,602.00	348.6	-2,253.4	13.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	40.00		-40.0	-
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	12,375.00	29,089.5	16,714.5	2.3 дах
<b>Татварын бус орлого</b>	<b>216,804.8</b>	<b>586,015.0</b>	<b>369,210.2</b>	<b>2.7 дах</b>
Торгуулийн орлого	171,304.8	352,690.3	181,385.5	2.0 дах
Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,500.0	118,401.5	112,901.5	21.5 дах
Бусад орлого	40,000.0	114,923.2	74,923.2	2.8 дах
<b>Нийт орлогын дүн</b>	<b>1,389,730.7</b>	<b>2,083,619.7</b>	<b>693,889.0</b>	<b>149.9</b>

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд газрын төлбөр гүйцэтгэлээр 127,191.3 мянган төгрөг төвлөрсөн, газрын дуудлага худалдааны орлого 38,617.5 мянган төгрөгөөр, торгуулийн орлого 181,385.5 мянган төгрөгөөр давсан нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

**Давж биелсэн орлогууд:**

- **Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого:** Тус суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын өмнөх оны санхүүгийн тайлангаар үүссэн өглөгийг барагдуулсан, Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин хөлс, шагнал, урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутган тооцох татварын орлого нэмэгдэж, 969,965.0 мянган төгрөгийн орлого төвлөрч 276,460.4 мянган төгрөгөөр давсан,
- **Газрын дуудлага худалдааны орлого:** Иргэдийн газар эзэмших хэрэгцээ ихэссэн, тайлант онд сумын 9 байршилд газрын дуудлага худалдааг зохион

байгуулснаар 44,049.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, 38,617.5 мянган төгрөгөөр давсан,

- **Торгуулийн орлого:** Өмнөх онд үүссэн торгуулийг иргэн, аж ахуйн нэгжүүд төлж барагдуулсан, Дархан - Улаанбаатар чиглэлийн автозам ашиглалтад орсон, Замын цагдаагийн хэсгээс аян зохион байгуулж, ажилласантай холбоотойгоор 352,690.3 мянган төгрөгийн орлого төвлөрч, 181,385.5 мянган төгрөгөөр давсан.

#### **Тасарсан орлого:**

- **Малд ногдуулах албан татвар:** Тайлант хугацаанд тус суманд өвөлжилт хүндэрснээс мал ихээр хорогдож, малчин болон мал бүхий иргэдийн орлого буурч, төлбөр төлөлт хангалтгүй байснаас 231,585.4 мянган төгрөгийн орлого төвлөрч, 66,914.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,229,870.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 82 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 193,995.2 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 599,267.3 мянган төгрөгөөр тус тус баталсан бол дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 60 дугаар тогтоолоор сумын төсвийн орлогыг 1,346,974.8 мянган төгрөг, өөрийн орлогыг 5,000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 493,872.2 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 22,027.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, эх үүсвэр болон нийт зарлагыг **2,661,136.5** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгож, аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 179,142.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 72 дугаар тогтоолоор дараах төсвийн тодотголыг хийсэн байна. Үүнд:

#### **Төсвийн орлогын өөрчлөлт:**

- Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлогыг 7,255.9 мянган төгрөгөөр,
- Торгуулийн орлогыг 30,000.0 мянган төгрөгөөр,
- ОНХС-ийн эх үүсвэрийг 105,979.8 мянган төгрөгөөр,
- Өөрийн орлогыг 500.0 мянган төгрөгөөр,
- Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 179,142.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,

#### **Төсвийн зарлагын өөрчлөлт:**

- Сумын ОНХС-ийн зардлыг 105,979.8 мянган төгрөгөөр,
- Төрийн өмчийн барилгын тогтмол зардлыг 96,190.1 мянган төгрөгөөр,

- Сумын ЗДТГ-ын цалингийн зардлыг 96,146.1 мянган төгрөгөөр,
- Сумын ИТХ-ын цалингийн зардлыг 24,562.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр **2,984,015.0** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,670,795.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 1,138,219.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 175,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 373,137.9 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 1,389,730.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, ОНХС-ийн эх үүсвэрээр 705,247.2 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 515,899.2 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр харуулбал:*

<i>/мянган төгрөгөөр/</i>					
№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	157,447.5	135,009.2	22,438.3	85.7
2	Засаг даргын тамгын газар	973,566.1	924,657.1	48,909.0	95.0
3	Орон нутгийн хөгжлийн сан	1,138,219.4	1,047,452.5	90,766.9	92.0
4	Хоршоо хөгжүүлэх сан	181,427.0	176,534.9	4,892.1	97.3
5	ЕБС	296,675.2	296,675.2	-	100.0
6	Эрүүл мэндийн төв	55,755.5	55,618.7	136.8	99.8
7	Цэцэрлэг	82,911.8	79,426.1	3,485.7	95.8
8	Соёлын төв	98,012.5	96,772.5	1,240.0	98.7
	<b>Нийт дүн</b>	<b>2,984,015.0</b>	<b>2,812,146.3</b>	<b>171,868.7</b>	<b>94.2</b>

*Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 229,823.7 мянган төгрөг, орон нутгийн орлогоос 1,965,218.2 мянган төгрөг, өөрийн орлогоос 118,401.5 мянган төгрөг, ОНХС-аас 705,247.1 мянган төгрөг, нийт **3,018,690.6** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,812,146.3** мянган төгрөг буюу 94.2 хувьтай байгаа нь урсгал зардлыг 81,101.8 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 90,766.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 24,348.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 8,100.6 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 4,461.0 мянган төгрөгөөр, нормативт зардал 410.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 6,509.9 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 3,599.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 12,676.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 4,363.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 16,631.4 мянган төгрөгөөр зэрэг нийт 81,101.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 11 төсөл, арга хэмжээнд 1,138,219.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,047,452.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 90,767.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

ХХС-аас олгохоор төлөвлөсөн 175,000.0 мянган төгрөгийн зээлийг бүрэн олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ЗДНХ-өөс 1,431.7 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 78,741.5 мянган төгрөг, Шинэ хөдөө төслийн 49,000.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас хамтарсан багийн зардалд 300.0 мянган төгрөг, камержуулалтын зардалд 8,701.7 мянган төгрөг, ГБХЗХГ-аас хүүхдийн чуулганы дэмжлэг 600.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс тооллогын зардалд 1,853.1 мянган төгрөг, БТСГ-аас зорилтот бүлгийн иргэдийн дундах тэмцээнд 800.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 38,733.4 мянган төгрөг зэрэг нийт **180,161.4** мянган төгрөгийн эх үүсвэрийг 8 хөтөлбөрийн 10 арга хэмжээний дараах зардлуудад зарцуулсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардалд 5,468.5 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардалд 2,719.6 мянган төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардалд 7,700.0 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардал 10,801.7 мянган төгрөг,
- Хөрөнгийн зардалд *аймгийн ОНХО-ын шилжсэн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ЭМТ-ийн өргөтгөлийн их засвар* 128,996.4 мянган төгрөг зэрэг нийт 155,686.2 мянган төгрөгийг зарцуулж, 24,475.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 1,138,219.4 мянган төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна.

Гүйцэтгэлээр шууд худалдан авах 3, харьцуулалтын аргаар гүйцэтгэх 3, нээлттэй тендер шалгаруулах 4, нийт 10 төсөл, арга хэмжээний худалдан авах

ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 10. Баянгол сумын 2023 оны худалдан авах ажиллагааны тайлан:

*Имянган төгрөгөөр/*

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Төлвлөсөн төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			ШХА		Харьцуулалтын арга		НТШ	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХС	10	1,130,719.4	3	53,500.0	3	165,000.0	4	912,219.4

*Эх сурвалж: tender.gov.mn*

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн зардлын данстай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дүгээр сарын 04-ний өдрийн 72 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 3,151,643.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **31,516.4** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулаагүй,
- Хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулаагүй,
- Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан аваагүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Хүснэгт 11. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал*

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн тоо	Хугацаа хоцроосон
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	178	168	10
2	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	182	171	11
3	Сумын Засаг даргын Тамгын газар	182	171	11
	<b>Нийт дүн</b>	<b>542</b>	<b>510</b>	<b>32</b>

*Эх сурвалж: [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)*

1. Тайлант хугацаанд Баянгол сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 27-29 төрлийн нийт 542 мэдээллээс 510 мэдээллийг хугацаанд нь, 32 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудас хөтлөлт нь Шилэн дансны тухай, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 122 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 89,948.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 171,667.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	5,971.3	2	5,971.3	100
Албан шаардлага	2	13,955.3	2	13,955.3	100
Зөвлөмж	2	90,000.0	2	90,000.0	100
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>109,926.6</b>	<b>6</b>	<b>109,926.6</b>	<b>100</b>

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2022, 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

## **АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 702,278.5 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

### **Залруулсан алдаа:**

- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Мал ариутгалын дүк машин худалдан авах, Ковш худалдан авах, Гэр хорооллын явган хүний замыг хатуу хучилттай болгох ажил зэрэг нийт **702,278.5** мянган төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг барилга байгууламж дансанд бүртгэснийг тус тусын холбогдох тээврийн хэрэгсэл, зам гүүрний байгууламж данснүүдэд залрууллаа.

Аудитаар нийт **110,997.0** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **4,559.2** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **21,902.5** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, **84,535.3** мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж өглөө.

### **5.1 Төлбөрийн акт:**

#### **Сумын ЗДТГ:**

1. Албан хаагчдын цалин, нэмэгдэл, тусламжийг **3,313.5** мянган төгрөгөөр илүү тооцож, олгосон байна. Үүнд:

- Төрийн захиргааны 6 албан хаагчид тооцооллын алдааны улмаас 790.4 мянган төгрөг илүү тооцож, олгосон,
- Сумын Засаг дарга Р.Батжаргалд ээлжийн амралтыг 216.3 мянган төгрөгөөр илүү тооцож, олгосон,
- Үйлчлэгч Л.Дүүриймаагийн ээлжийн амралтыг үндсэн цалинтай давхардуулан, 445.4 мянган төгрөгийг тооцож, олгосон,
- Тохижилт үйлчилгээний нярваар ажиллаж байсан М.Бямбаад өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тусламжийг 1,703.1 мянган төгрөгөөр, ээлжийн амралтыг 158.3 мянган төгрөгөөр тус тус илүү тооцож, олгосон байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.1 дэх “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин, нэмэгдэл, тусламжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## Сумын ИТХ:

2. ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Мөнхжаргалд 2016 онд олгогдсон туслах түшмэлийн зэрэг дэвийг /2016 оны 09 дүгээр сард тус албан тушаалаас чөлөөлөгдсөн/ үндэслэн ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалын дөтгөөр зэрэг дэвээр тооцож, **1,245.7** мянган төгрөгийн нэмэгдлийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.3 дахь “Төрийн захиргааны ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг ... аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус шийдвэрлэнэ.”, 2.4 дэх “Төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох саналыг уг албан хаагчийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр илүү олгосон зэрэг дэвийн нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага:

1. Сумын ЗДТГ-ын орон тоонд батлагдаагүй нотариатын асуудал хариуцсан гэх үндэслэлээр төрийн захиргаа, хууль эрх зүйн мэргэжилтэн Б.Хажидмаад үндсэн цалингийн 40 хувиар тооцож, **649.5** мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тооны хүрээнд ажиллагсдын цалин хөлсийг тогтоож байх албан шаардлага хүргүүлэв.

2. ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс зориулалт бусаар болон анхан шатны баримтын бүрдэлгүйгээр дараах **21,253.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Жил бүр давтагддаг, урьдчилан төлөвлөх боломжтой нохой устгал, малын сэг зэм, хог түрж булшлах арга хэмжээнд 20,293.0 мянган төгрөг,
- Холбогдох шийдвэргүйгээр 960.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Сангийн сайдын 2021 оны

61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 1.2 дахь “ ... урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан гэдгийг **жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг ... гэж ойлгоно.**” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

3. Сумын ИТХ, ЗДТГ нь жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн, харилцагч аж ахуйн нэгж, байгууллагуудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулсан нь баримтаар бүрэн нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1: жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг иж бүрэн хийж, баримтжуулах, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулах албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Аймгийн ОНХС-аас эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн “Сумын төвийн уурын зуухны шинэчлэлийн ажил”-д захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байхад гүйцэтгэгч Бэсүжин констракшн ХХК, хүлээн авагч Анужээ ХХК-ийн хооронд хийгдсэн 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн №01 дүгээр “Бараа хүлээлгэж өгсөн акт”-аар уг төсөл, арга хэмжээг хүлээн авч, 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Бэсүжин констракшн ХХК-д **79,996.4** мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.9 дэх “Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, ... тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, ... хамтран хянаж, баталгаажуулахаас ... үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.” гэж заасантай нийцэхгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Захиалагчийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлж, тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, хүлээн авсан комиссын акт, холбогдох бусад баримт бичгийг үндэслэн төлбөрийг гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.

**2.1 Илрүүлэлт:** Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын ЭБАТ-ны нэмэгдлийг гүйцэтгэж буй ажлын ачаалалтай уялдуулалгүйгээр хэт өндрөөр буюу 40 хувиар тооцож, А.Бадамдоржид /2023 оны 1-10 сар хүртэл/ 1,980.7 мянган төгрөг, Д.Мөнхжаргалд /2023 оны 10-12 сард/ 958.2 мянган төгрөг, нийт **2,938.9** мянган төгрөгийг тооцож, олгож байна.

Энэ нь аймгийн ИТХ-ын 2022 оны 208 дугаар “Сумдын ИТХ-ын дарга нарт” хүргүүлсэн албан бичгээр хүргүүлсэн “ЭБАТ-ны нэмэгдлийг аймгийн Засаг даргын захирамжийг<sup>1</sup> жишиг болгон мэдүүлэг гаргагчдын тоонд харгалзуулан тогтоон өгч байх” гэсэн зөвлөмжийг зөрчсөн байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** ЭБАТ-ны нэмэгдлийг мэдүүлэг гаргагчдын тоонд харгалзуулан, дээрх зөвлөмжийн дагуу тогтоон өгч байх зөвлөмж өгөв.

**3.1 Илрүүлэлт:** Жилийн эцэст НДШ-ийн тооцоог нийлж өр төлбөр, авлагагүйгээр баталгаажуулсан хэдий ч тайлант оны цалингийн зардлыг тулган баталгаажуулахад ажиллагсдын цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн цахим системд зөрүүтэй оруулснаас ажил олгогч, даатгуулагчаас төлсөн НДШ-ийн **1,600.0** мянган төгрөгийн авлага үүсэхээр байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**3.2 Өгсөн зөвлөмж:** Нийгмийн даатгалын цахим системийн шинэчлэлтэй холбоотойгоор зөрүүг тооцоолж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах боломжгүй байх тул 2024 оны 2 дугаар улиралд багтаан Нийгмийн даатгалын байгууллагатай дахин тооцоо нийлж, тулган баталгаажуулах зөвлөмж өгөв.

**Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Аймгийн Засаг даргын 2022 оны Б/14 дүгээр “Цалингийн нэмэгдлийн хувийг шинэчлэн тогтоох тухай” захирамжийн хавсралтаар баталсан “Цалингийн нэмэгдлийн хувийг тогтоосон хүснэгт”-ийн 16-д “Баянгол сумын ЗДТГ-10%”,

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
							Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо
Баянгол сумын ТТЗ	1	702,278.5			1	702,278.5	1	702,278.5				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>702,278.5</b>			<b>1</b>	<b>702,278.5</b>	<b>1</b>	<b>702,278.5</b>				

/мянган төгрөгөөр/

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянгол сумын ТТЗ	7	110,997.0	1	4,559.2	3	21,902.5	3	84,535.3				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>110,997.0</b>	<b>1</b>	<b>4,559.2</b>	<b>3</b>	<b>21,902.5</b>	<b>3</b>	<b>84,535.3</b>				

/мянган төгрөгөөр/

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс	
		Төлбөрийн акт	Албан шаардлага
			Зөвлөмж

/мянган төгрөгөөр/

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Баянгол сумын ТТЗ	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>		